



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 0164

Хараат

Шүлхийн өвчнөөс урьдчилсан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, аймгийн Засаг даргын 2023 оны 10 дүгээр сарын 10-ний өдрийн А/588 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчид, мал бүхий иргэдэд мэдээлэл хүргэн, бэлэн байдлыг хангуулж гоц халдварт Шүлхий өвчний дархлаажуулалтад үхэр сүргийг бүрэн хамруулах арга хэмжээг 2023 оны 10 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд зохион байгуулахыг багийн Засаг дарга нар, мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд үүрэг болгосугай.

2. Дархлаажуулалтын арга хэмжээг удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Т.Өлзийбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Н.БАТГЭРЭЛ

4823000138